


Зөв Эхлэл - Бэлтгэл Ангийн Үнэлгээ

Эцэг эх болон асран хамгаалагчдад зориулсан хөтөч

Зөв Эхлэл - Бэлтгэл Ангийн Үнэлгээ нь улсын хэмжээний үнэлгээ ба бэлтгэл анги эхлэхийн өмнө багш нарт сурагч бүрийн Англи хэлний бичгийн болон тоон ур чадварыг нь тодорхойлоход туслах болно.



Хүүхдүүд сургуульд анх орохдоо бичгийн болон тоон ур чадварын түвшин мөн хүрээлэн буй орчин, эргэн тойрныхоо хүмүүсийн нөлөөллөөр олж авсан ойлголт, мэдлэгийн хувьд харилцан адилгүй байдаг. Зөв Эхлэл - Бэлтгэл Ангийн Үнэлгээ нь бичгийн болон тоон агуулгуудыг багтаасан ба багш нарт тухайн сурагчийн давуу тал болон хэрэгцээг нь тодорхойлсон мэдээллийг олгох болно.

Энэхүү үнэлгээ нь сурагчдын мэдлэг дээр тулгуурласан заах арга зүйн болон сургалтын хөтөлбөр боловсруулахад багш нарт туслах болно. Багш нар сурагч бүртэй тусгайлан ажиллаж тэдний хийж чаддаг зүйлд нь илүү анхааран үнэлэх болно. Таны хүүхэд уг үнэлгээнд зориулан бэлтгэх эсвэл хичээллэх шаардлагагүй. Хүүхэд бүрийн суралцах түвшин ялгаатай учир хэрвээ таны хүүхэд асуултуудад хариулж чадахгүй байвал санаа зовох хэрэггүй.

Үнэлгээ хийсний дараахан, багш таны хүүхэд үнэлгээний үеэр ямар ур чадварыг харуулж, ямар мэдлэг, ойлголттой байгаа тухай мэдээллийг танд өгөх болно.

Зөв Эхлэл - Бэлтгэл Ангийн Үнэлгээнд бүх сурагчид хамрагдах боломжтой. Хэрвээ таны төрөлх хэл Англи хэл биш эсвэл таны хүүхдэд нэмэлт тусламж хэрэгтэй бол сургуультай холбогдон хэрхэн тусламж авах боломжтой тухай ярилцаарай.

Бичгийн ур чадварын үнэлгээ

Бичгийн ур чадварын асуултууд нь таны хүүхэд өөрийн нэрээ бичиж чадах эсэх, авиа, үсэг болон ойр зуурын үгсийг таньж чадах эсэх, мөн богино ном уншиж өгөхөд агуулгыг санаж байгаа эсэхийг нь тодорхойлох зорилготой.

Бичгийн ур чадварын үнэлгээний үеэр багш таны хүүхдээс дараах жишээ бүхий асуултуудыг асуух болно. Үүнд:

- Эдгээр үгнүүдийг сонсоорой: map, tap. Эдгээр үгтэй авиа нийцсэн өөр ямар үг байж болох вэ?
- (богино ном уншиж өгсний дараа) 'Сая уншиж өгсөн үлгэрийн тухай надад яриад өгөөч?'

Эдгээр асуултууд нь таны хүүхэд ижил авиа бүхий үгсийг таних чадвартай эсэх мөн богино ном уншиж өгөхөд агуулгыг санаж байгаа эсэхийг тодорхойлоход багш нарт туслах болно. Эдгээр нь хүүхэд сургуульд анх ороод эхний жилд эзэмших чухал бичгийн ур чадварууд юм.

Тоон ур чадварын үнэлгээ

Тоон ур чадварын асуултууд нь анхан шатны түвшний тоон агуулгуудыг багтаасан ба сурагчийн тоолох чадвар хэр түвшинд байгааг, аль тоонуудыг таньж байгааг, юмсыг тоолж чадах эсэх, бага тоонуудыг нэмж, хасаж чадах эсэх, мөн давтагдсан хэв маягуудыг таних чадварыг нь тодорхойлох зорилготой.

Тоон ур чадварын үнэлгээний үеэр багш таны хүүхдээс дараах жишээ бүхий асуултуудыг асуух болно. Үүнд:

- 'нэгээс эхлээд тоолоорой. Би хэзээ зогсохыг чамд хэлэх болно'
- 'энэ хэдийн тоо вэ?' (5)

Эдгээр асуултууд нь таны хүүхэд тоонуудыг таньж байгаа эсэх мөн үргэлжлүүлэн тоолох чадвартай эсэхийг тодорхойлоход багш нарт туслах болно. Эдгээр нь хүүхэд сургуульд анх ороод эхний жилд эзэмших чухал тоон ур чадварууд юм.

Зөв Эхлэл - Бэлтгэл Ангийн Үнэлгээний талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл хүүхдийнхээ сургуультай холбогдоорой.

Хэрвээ танд орчуулагч хэрэгтэй бол Утсан Орчуулгын Үйлчилгээ болох 131 450 дугаараар холбогдоорой. Тэд таныг сургуультай холбогдон ярилцахад тухайн хэлний орчуулагчийг бэлэн байлгах болно. Энэхүү үйлчилгээ нь үнэ төлбөргүй юм.